



ЦЭНХЭР АЛТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ.

2021.XII САР

Ц.СОСОРБАРАМ: БАРУУН МОНГОЛД ТҮҮХЭНД БАЙГААГҮЙ ТОМ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХИЙГДЭНЭ



Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станц. Энэ том төсөл олон хүний анхаарлын төвд байна. Ирэх хавраас ажил нь эхлэх энэ төслийн талаар тодорхой ойлголт өгөх зорилгоор Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцын Байгаль орчин, нийгмийн үнэлгээний түншлэлийн багийн ахлагч, техникийн ухааны доктор Монгол Улсын зөвлөх инженер, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Ц.Сосорбарамтай уулзлаа.

Эрчим хүчний үйлдвэрлэл үе үеийн Засгийн газрын анхаарлын төвд байсан нь мэдээж. Энэ сэдвээр ярилцлагаа эхлэх үү?

-Тийм ээ. Монгол оронд үйлдвэржилт, хотжилт хүчтэй хөгжиж эхэлсэн нь 1960-1980 оны үе юм. Тэр үеийн төр засгийн бодлого Хөдөө аж ахуйн үйлдвэржсэн орон болгох байлаа шүү дээ. Энэ үеэс Эрчим хүчний үйлдвэрлэл эрчимтэй эхэлсэн гэж болно. Үйлдвэр комбинатууд бий болж, улмаар Дулааны цахилгаан станцууд баригдаж эхэлсэн. Хажуугаар нь Усны энерги ашиглах боломж судлах ажил ЗХУ-ын асар том судалгааны

байгууллагын хүч хөрөнгөөр хийгдэж эхэлсэн түүхтэй. Ингээд 1967 оноос ЗХУ-ын туслалцаа дэмжлэгтэйгээр Гидропроект Монголд орж ирж судалгаа хийсэн юм.

Сэргээгдэх эрчим хүчний бүрэлдэхүүнд ордог Усан цахилгаан станцын судалгааг хаана хаана хийсэн юм бол?

-Дээрх ажлын хүрээнд Монгол орны Усны эрчим хүчний нөөцийг тогтоох судалгаа хийгдэж 17 гол дээр усны эрчим хүчийг ашиглахаар тогтоосон. Үүнд Эгийн голын цахилгаан станц, Шүрэнгийн цахилгаан станц, Ховд гол дээр Эрдэнэбүрэнгийн

цахилгаан станц мөн Дөргөн, Тайширын цахилгаан станцын судалгаа хийгдсэн юм. Анхны эдгээр судалгааг хийж байхад эрчим хүчний хэрэглээ бага байсан л даа.

Хориод жилийн өмнөөс л Усан цахилгаан станцууд барьж эхэлсэн байх. Одоо тэдгээр станцууд эрчим хүчний хэрэглээний хичнээн хувийг хангаж байдаг юм бол оо?

-Анхны судалгаа хийж байсан үетэй одоо үеийг харьцуулах юм бол хүн ам 2-3 дахин, эрчим хүчний хэрэглээ ч мөн төд дахин өссөн шүү дээ. Одоо бол Дөргөний Усан цахилгаан станц баруун гурван аймгийн эрчим хүчний хэрэглээний дөнгөж 24 хувийг л хангаж байгаа. Үлдсэн 76 хувийг ОХУ-аас авч байгаа л даа.

Баруун аймгуудын маань эрчим хүч ОХУ-аас 76 хувийн эрхшээлтэй байна гэсэн үг үү? Тэд эрчим хүчээ манайд ямар үнээр нийлүүлдэг юм бол оо?

-Тийм шүү дээ. Тэндээс 76 хувийн хамааралтай байна гэсэн үг. Оросууд нэг квт/цаг эрчим хүчийг 280-315 төгрөгөөр Монгол улсад экспортолдог. Гэтэл Дөргөний Усан цахилгаан станц дээр нэг квт/ цаг энергийг 37 төгрөгөөр үйлдвэрлэдэг. Асар том зөрөө ялгаа харагдаж байгаа биз. Тийм учраас эрчим хүч импортолж буй зардлыг Монголдоо үлдээх, цахилгаан эрчим хүчээ дотоодын үнээр боловсруулах хэрэг зориг бидэнд байгаа биз. Энэ зорилгоор



-Тийм ээ. Нөгөө талаар Монгол Улс нэгдсэн Киотогийн протколын дагуу сая сая тонн хүлэмжийн хийг ялгаруулах нөхцөл багасна. Энэхүү сэргээгдэх эрчим хүчийг ашигласнаар байгаль орчинд ямар эерэг нөхцөл байдал үүсэх вэ гэдгийг нарийн тооцож гаргасан байгаа л даа.

Хэдий хэрийн хөрөнгө мөнгөөр босох билээ, Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станц маань?

-Энэ бол баруун Монголд хэрэгжиж байгаа хамгийн том хөрөнгө оруулалт бөгөөд нийтдээ 271 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар босох юм. Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн тооцоо судалгааг ахалж удирдсан хүний хувьд хэлэхэд энэ бол үнэхээр том төсөл.

Том улс гүрнүүд ч хатуу түвшинээс татгалзаж, сэргээгдэх эрчим хүч ашиглахаа мэдэгдсээр байгаа энэ цагт манайх бас зоригтой, томоохон шийдвэр гаргажээ дээ?

-Тийм ээ. Дэлхийн бүх улс орон хатуу түлш шатаадаг эх үүсвэрээс татгалзаж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл өсөн нэмэгдсээр байгаа. Энэ л зөв зүй тогтолцоотой Монгол улс бас хөл нийлүүлж байгаа хэрэг мөн.

Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцыг барих шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар 2017 онд гаргасан юм.

Уг санцыг барих судалгааны ажил ТЭЗҮ нь хийгдээд дууссан уу?

-Тэгэлгүй яахав. Судалгааны ажил хийгдэж, Техник эдийн засгийн үзүүлэлт батлагдсан. Байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ батлагдсаны дараа “Экзим” банкны хөнгөлөлттэй зээлээр барих асуудал шийдэгдсэн. Улмаар ирэх оны дөрөвдүгээр сард ажил нь эхлэх гэж байна.

Энэ Усан цахилгаан станцыг ямар хугацаанд барьж дуусгах вэ? Ямархуу хүчин чадалтай станц бий болох юм бол?

-Бүхий л ажлыг 61 сарын дотор хийж дуусгана гэж төлөвлөсөн байгаа. Одоогоор баруун аймгуудын Эрчим хүчний нэг жилийн хэрэглээ 155 сая/квт цаг байгаа юм. Энэ станц ашиглалтад орсноор жилд 366 сая квт цаг эрчим хүчийг үйлдвэрлэнэ. Ингэснээр баруун таван аймгийн Эрчим хүчийг 10 жилийн дотор асуудалгүй хангана гэсэн үг.

Улмаар ОХУ, БНХАУ-аас авдаг цахилгааны төлбөр мөнгө Монгол Улсад үлдэнэ. Дээр нь Төвийн эрчим хүчний системийн оргил ачааллын бэрхшээлийг давахад бид дотоодоосоо цахилгаан нийлүүлэх боломж үүснэ.

Олон сайхан боломж, хэмнэлтүүд бий болох нь гэж ойлгож байна. Нөгөө талаар байгаль орчинд эерэг нөхцөл байдал үүснэ биз дээ, сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж эхэлснээр?



Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцыг барьж байгуулахын тулд олон олон тогтоол, шийдвэр гарч байгаа нь мэдээж. Тэнд нутаглаж байгаа малчдын бэлчээр ус, өвөлжөө хаваржаа гээд олон л асуудал урган гарч байгаа байх даа?

-Энэхүү Цахилгаан станцыг барихын тулд Монгол Улсын Засгийн газар тогтоол гаргаж 28 000 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авсан юм. Үүнээс 9400 га нь усанд автагдах талбай. Тэрхүү талбайн 5400 га нь Баян-Өлгийн Баяннуур суманд, 4800 га нь Увс аймгийн Өмнөговь сумын нутаг дэвсгэрт хамаарч байгаа. Одоогоор тэдгээр нутаг оронд өвөлжөө хаваржаа нь байгаа 270 өрхийн газрыг сольж, Газрын тухай хуулийн тодорхой заалтыг үндэслэн нөхөн олговор олгох тооцоог хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Мэдээж энэ төсөл хэрэгжихийн өмнө тухайн нутаг орны удирдлага, ард иргэдийн дунд хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулсан байх. Учиргүй татгалзаад, эсэргүүцээд, “Нутаг орноо өгөхгүй” гэх “эх орончид” гарч ирсэнгүй юу?

-Хуулийн дагуу бид төсөл хэрэгжиж байгаа нутгийн олон нийт, засаг захиргаадыг баг болгон хэлэлцүүлэг зохион байгуулахад Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн зургаан багийн таван баг нь олонхоороо дэмжсэн. Харин Увс аймгийн Улиастай баг эсэргүүцсэн.

“Хэдэн үеэрээ аж төрсөн өвөлжөө, хаваржаагаа өөр зориулалтаар өгөхгүй” гэж эсэргүүцэх улс олон байдаг шиг билээ. Малчдын амь амжиргаа бэлчээр устай холбоотой болохоор арга ч үгүй байдаг биз ээ?

-Хуулийн дагуу бол тэгэх учиргүй л дээ. Тэдгээр иргэд бол тухайн өвөлжөө хаваржааны газраа эзэмшлийн хэлбэрээр л ашиглаж байгаа. Төрийн Эзэмшлийн газар дээр өмчийн харилцааны асуудал яригдах ёсгүй. Төр засаг өөрийн мэдлийн газар орныг



захиран зарцуулах эрхтэй. Харин нүүлгэн шилжүүлэх зэрэгт гарах хөрөнгө мөнгийг нөхөн олговроор төлөхөөр тусгагдсан байгаа. Энэ ажлыг зохион байгуулахад 9,2 тэрбум төгрөгийн зарцуулна гэж урьдчилан тооцоолсон. Үүний тулд ажлын дэд хэсэг нарийвчлан нэмэгдүүлэх боломж үүсч байгаа. Төрийн хуулийн дагуу л бүх юм явна.


Монгол Улсынхаа хөгжил, дэвшил, ирээдүй хойчийг боддог хүн бүр л дэмжмээр төсөл юм даа. Эх орноо гэдэг хүн бол бушуу түргэн л ашиглалтад ороосой гэж бодох байлгүй дээ?

-Тийм ээ, энэхүү төсөл нь Монгол улсын тогтвортой хөгжил, эрчимжсэн Хөдөө аж ахуйг эрхлэх, өртөг шингээсэн үйлдвэрлэл явуулах хэтийн хөгжил бөгөөд өнөөдөр эсэргүүцэж байгаа тэр хүмүүсийн ач гуч, үр хойчийн соёл иргэншилд онцгой үүрэг

гүйцэтгэнэ. Энийг харин тэдгээр хүмүүс ойлгохыг хүсэхгүй байгаа юм. Зөвхөн өнөөдрийн хувийн эрх ашгаа өндөрт тавьж, иргэнийхээ эрх, эрх чөлөөг иргэний эрх ба үүргийн тэнцвэртэй харьцааны дээр нь тавиад байгаа юм. Энэ нь юм ойлгодог, мэддэг олон түмнийг бухимдуулж байгаа юм.

Усан цахилгаан станц барихын тулд усыг хааж боож, уул нурууг тэсэлж... янз бүрийн л үйл ажиллагаа явагдах нь мэдээж. Байгаль орчин, тухайн газар орчинд ямар ямар нөлөө, өөрчлөлтийг үзүүлэх талаар дэлгэрэнгүй тайлбарлаж хэлэхгүй юу?

-За, тэгэхлээр, Байгаль орчны хувьд гол нөлөөлөлд өртөж байгаа нь газар юм. Газарт хамгийн том нөлөөлөл үзүүлнэ. Нийтдээ 9000 га газар усны дор орж, хөдөө аж ахуйн газрын ангилалттай газар нь ус бүхий газрын ангилалд



шилжинэ. Хоёрт, агаарт төдийлөн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин ч бичил уур амьсгалд болон биологийн олон төрөл зүйлийн популяци ба нуга намаг бүхий орчин үүснэ. Байгал орчиндоо эерэг нөлөөтэй гэдгийн хэлэх нь зүйтэй. Усны чанарт сөрөг нөлөө байхгүй. Харин 1,4 сая куб км усны нөөц хуримтлал бий болно. Ингэснээр орчны нуга намаг бүхий ургамлан бүрхэвчтэй, ландшафтын хувьд үзэсгэлэнтэй орчин үүснэ. Загасны популяцад сөрөг нөлөө байхгүй.

Усанд автах тухайн газарт мод бутлаг ургамлуудыг яах вэ? Өөр газар шилжүүлэн суулгах уу?

Нийтдээ 880 га газарт байгаа модлог бутлаг ургамал усан дор орно. Энэхүү ойн биомассыг Цамбагарав, Алтанхөхийн дархан газрын бүсэд дүйцүүлэн ургуулж нөхөх зардлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаа.

Тухайн газар нутаг түүхийн өв соёлын нандин сайхан дурсгалтай нь мэдээж. Баруун аймгууд хүн чулуу, буган хөшөө зэрэг ховор сайхан дурсгал ихтэй. Тэр бүхнийг яаж хадгалж, хамгаалах юм бэ?

-Тийм ээ. Түүх өв соёлын 206 дурсгалын зүйлс тэмдэглэгдэж, бүртгэгдсэн. Эдгээрийг нүүлгэн шилжүүлнэ. Энэ ажилд 1,4 тэрбум төгрөгийг зарцуулахаар тусгагдсан байгаа.

Усан цахилгаан станц барьж ашиглаж байгаа улс орнуудын турилагыг судалсан зүйл танд их бий байлгүй. Манайд явагдаж байгаа ажлыг тэдэнтэй харьцуулахад ямар дүр зураг харагддаг вэ?

-Монгол шиг далайд гарцгүй, Монголоос 17 дахин жижиг газар нутагтай Лаос улс гэхэд л дэлхийн том гол Меконг мөрөн дээр 5 усан цахилгаан станц барьж экспортынхоо 87 хувийг, дотоодын

эрчим хүчнийхээ 97 хувийг хангаж байгаатай харьцуулах юм бол Монгол улсын энэ чиглэлийн хөгжлийг тэг /нойль/ гэж үзэж болно. Монголоос дөрөв дахин жижиг газар нутагтай, эдэлбэр газар багатай, уулын бүсэд амьдардаг 130 сая хүнтэй, цагаан будааны таримлын дэлхийн гуравны нэг хувийг гаргадаг Япон улс өнөөдөр 57000 Усан цахилгаан станц барьж ашиглаж байна. Тэр бүхнийг газар тариалан эрхэлж амьдардаг хүмүүс нь ойлгоод дэмжээд явдаг юм билээ. Энэ бүхнээс харьцуулахад хангай, хээр тал, говь хосолсон, малын бэлчээрийн гачигдалд орохгүй манай орны иргэдэд энэ бол асуудал биш. Үүнийг ч манай ард түмэн ойлгож дэмжиж байгаа гэдэгт би итгэдэг.

Ярилцсан А.Лхагва



УСНЫ САЛБАРЫН АХМАД АЖИЛТАН МЯГМАРЫН СҮРЭНХОРЛОО “БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН” БОЛЛОО

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх зарлиг гарган эрхэлсэн салбартаа амжилт гаргасан иргэдэд төрийн дээд цол, одон, медаль гардууллаа.

Геофизикийн цахилгаан хайгуулын олон төрлийн арга ашиглаж, газрын гүний усны эрэл, судалгааг олон жилийн турш цөл, тал хээр, мөнх цэвдэгтэй бүс нутагт хийж, хэдэн зуун уст цэг тогтоон, гүний өрөмдмөл худаг гаргаж, газар тариалан, малын бэлчээр, төв суурин газрыг усжуулахад бодитой хувь нэмэр оруулсан, олон арван мэргэжилтэн бэлтгэсэн Усны газрын ахмад ажилтан Мягмарын Сүрэнхорлоод Байгаль орчны гавьяат ажилтан цол хүртээв.

М.Сүрэнхорлоо танд салбарын нийт хамт олны өмнөөс баяр хүргэе



САЛБАРЫН ШИЛДГҮҮДИЙГ АЛТАН ГАДАС ОДОНГООР ШАГНАЛАА

Тулгар төр байгуулагдсаны 2230, Их Монгол Улсын 815, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 110 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн, геофизикч Цэвээнжавын Батцэнгэл, Галба-Өөш Долоодын

говийн сав газрын захиргааны дарга Дашзэвэгийн Гансүхийг Төрийн дээд “Алтан гадас” одонгоор шагнасныг Усны газрын дарга Ш.Мягмар гардуулж өглөө.



“АРЬС ИРЭЭДҮЙ” ИРЭЭДҮЙГЭЭ ХАРЖ ЧАДЖЭЭ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВД НЭГЭН САЙХАН ҮЙЛДВЭР ҮҮДЭЭ НЭЭЛЭЭ. ЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ “НООС ИРЭЭДҮЙ” КОМПАНИ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭН АРЬС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛЛАА.



бөгөөд ” гэсэн суут удирдагчийн үг санаанд байнга байдаг” гэлээ. Нээлтийн үеэр Үндэсний Эрдмийн их чуулгын уртын дуучин Түмэнжаргал, “Хөсөгтөн” хамтлагийн хөгжимчид уран бүтээлийн дээжээ өргөн барилаа.

Нээлтийн үеэр Өвөрхангай аймгийн Засаг дарга Ишдорж “Жилдээ нэг сая арьс боловсруулах том сайхан үйлдвэр бий боллоо. Дээр нь бүтээгдэхүүнийг нь худалдан авах хүмүүс нь ирчихсэн байна. Өвөрхангай бол баруун аймгуудынхан зорчин явдаг төв цэг гол зам зам дээр байдаг. Тийм болохоор түүхий эдийн ханган нийлүүлэлт хангалттай. Бид ноосоо боловсруулаад гаргачихаж байна. Нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Удахгүй Өвөрхангайд яс боловсруулах үйлдвэр байгуулна. Ингэснээр малын гаралтай түүхий эдийг бүгдийг боловсруулдаг болох юм” гэлээ.

Үйлдвэрийн нээлтэд очсон Усны газрын дэд дарга Б.Баянмөнх “Бусад аймаг орон нутагт үлгэр жишээ болохуйц үйлсийг та бүхэн бүтээн цогцлоожээ.

“Арьс ирээдүй” үйлдвэр ийнхүү тулгаа тулж, галаа бадрааж байгаа нь энэ. Хонины нэхий, малын арьс шир үнэгүйдэн хайрцаг тамхи, боодол бохиноос ч хямдхан болж, хаа сайгүй хаягдаж байсан цаг ул болох эхлэлийг тэд ийнхүү эхлүүлжээ. Тус компани нь жилдээ нэг сая арьс боловсруулах хүчин чадалтай бөгөөд 100 гаруй ажлын байр шинээр бий болж байгаа ажээ. Үйлдвэрийн нээлтэд ХХААХҮЯ, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, тухайн үйлдвэрийн түнш байгууллагуудын төлөөлөгчид очсон байв.

“Арьс ирээдүй” үйлдвэрийн нээлтийн үеэр тус компанийн захирал хатагтай Б.Чимэдцэрэн: “Үйлдвэрлэл эрхлэгчдийн уулзалтад оролцоод сууж байхдаа манай компани юу хийж чадах вэ? гэдгийг бодож суусан. Ингээд арьс боловсруулах үйлдвэр байгуулья” гэж шийдсэн. Улмаар хөрөнгө оруулагч Баянмөнх нарт санал тавиад энэхүү үйлдвэрийг бүтээн босголоо. Үнэгүйдээд

байсан арьс ширийг боловсруулах үйлдвэртэй боллоо. Манайх жилдээ нэг сая арьс боловсруулна. Бид байгальд ээлтэй үйлдвэрийг бий болгохыг хүссэн. Тэр ч хүсэл зорилгодоо хүрч байгаа. Манай бүтээгдэхүүнийг худалдан авах гадаадын анхны түншүүд маань ч энд ирээд байна. ...Бид нэгэн зүгт зориглон хөдөлвөөс мэдэхгүй чадахгүй гэх зүйлгүй





Аймаг орон нутагтаа хамтарч юу хийж болдгийг танайх харууллаа. Өнгөрсөн намар Өвөрхангайд болсон Төвийн бүсийн сав газрын захиргаадын бүсчилсэн сургалтын үеэр танай “Ноос ирээдүй” үйлдвэрийг үзэж, ажил үйлстэй нь танилцаж байлаа. Ноос, арьс шир боловсруулах үйлдвэрүүд чамгүй их ус хэрэглэдэг. Ус цэвэршүүлэх байгууламж зайлшгүй байх ёстой. Энэ үйлдвэр хоногт 700 шоо метр ус цэвэрлэх байгууламж барьжээ. Эндээс гарч буй усаа үйлдвэрлэлээ дэмжсэн, ногоон хөгжлийг дэмжсэн бүтээгдэхүүн болгоорой. Жишиг болохуйц үйлдвэр бий болоход тань манай газар хамтран ажиллана. Олон улсын стандартад тавигддаг шаардлагууд танай дээр хэрэгжиж байгаад маш их талархаж байна” гэж хэллээ.

Хонь ямааны арьсыг боловсруулан торго шиг болгосон бүтээгдэхүүнийх нь дээжийг худалдан авахаар очсон гадны түншүүд нь үзэж сонирхож, компанийн удирдлагатай санал

бодлоо солилцож байгаа харагдсан. Үйлдвэрийн цэлгэр зааланд том том “торхнууд” эргэлдэж, үе үе усаа асгаж, хүнгэнэж дүнгэнэн сүртэй ажилладаг ажээ.



Энэ компанийн захирал, хатагтай Балдангийн Чимидцэрэн Ээрмэлийн үйлдвэрийн технологич инженерийн мэргэжилтэй ажээ. Тэрбээр 1982 онд ЗХУ-ын Ташкентын

нэхмэл хөнгөн үйлдвэрийн дээд сургуулийг төгссөн байна. Улмаар Политехникийн дээд сургуульд багшилж, Ээрмэлийн үйлдвэрт ажиллаж, эрдмийн зэрэг цол хамгаалж...Улс эх орондоо сурсан мэдсэнээ харамгүй өгчээ. Тэрбээр 2012 онд гавьяаны амралтандаа суугаад л энэ салбарт хүчээ өгч эхэлсэн байна. Түүний нөхөр Сүхбаатар нийслэл хотод ноос угаах үйлдвэр ажиллуулж байгаад нийслэлээс энэ чиглэлийн үйлдвэрийг гаргах шийд гарсны дагуу Өвөрхангайд шилжүүлэн авч иржээ. Тэд энэхүү “Ноос ирээдүй” үйлдвэрээ найман тэрбум төгрөгөөр босгосон гэдэг. Ташрамд сонирхуулахад Засгийн шийдвэрийг дагаж нийслэл хотоос нүүж шилжсэн нь ердөө ганц тэдний үйлдвэр гэж дуулдсан. Тэд хууль дүрмийг ягштал сахиж мөрдөхийг гол болгодог нь юухнаас ч ажиглагдана. Одоо эдний ноосны үйлдвэр жилдээ 3000 тн ноосон түүхий эд боловсруулдаг. Ялгах, угаах, самнах, шивмэл эсгий, зулхайн цех, оёдлын цех зэрэг долоон найман цехтэй. Бүтээгдэхүүнээрээ гэрийн эсгий, оёмол бүтээгдэхүүн хийнэ. Хөнжил, гудас, аяны хөнжил, төрөл бүрийн олбогууд нь эрэлт хэрэгцээ ихтэй байдаг бололтой. Самнасан ноосоо үйлдвэрүүдэд өгнө. Энд одоо 150 гаруй хүн ажиллаж байна. Дулааны улиралд 200 гаруй болж нэмэгддэг. Ноос самнах цех нь 24 цагаар ажилладаг ажээ.

“Хавар, цагаан сар гарангуут ноосны үйлдвэр түүхий эдгүй болчихдог байв. Жилийн дөрвөн улиралд түүхий эдтэй байлгах нэг боломж нь арьс нэхий боловсруулах үйлдвэртэй байх нь чухал юм байна. Ноосны маань хамгийн том эх үүсвэр нь арьс ширний үйлдвэр юм байна гэж бид мэдэрч ойлгосон юм. Тийм үйлдвэртэй болчихвол бид жилийн дөрвөн улиралд түүхий эдээр тасрахгүй юм байна гэж тооцсон юм. Ингээд үйлдвэртэй болох шийдвэрээ гаргаад өнгөрсөн хавар гуравдугаар сард арьс



удирдлага яаж хаягдалгүй бүтээгдэхүүн хийж чаддагийг үзүүлж, үлгэр жишээ болж байдаг хүмүүс. Арьс хөрснөөс гарсан ноосоороо эсгий хийчихэж байна. Оёмол сүлжмэл бүтээгдэхүүн хийнэ. Нүүрснээс гарсан үнсээрээ блок хийгээд, хашаа, агуулах саваа барьчихаж байна. Уурын зуухнаас гарч байгаа утаа нь хүртэл цагаан байгааг анзаарсан байлгүй. Шинэ технологи ашиглаад шийдчихэж байна” гэж удирдлага, хамт олноо магтлаа.

Маргаашаа, ирээдүйгээ харж чадсан энэ компанийн удирдлага нэг хүн, нэг хамт олон нийгэмд ямархан их гэгээ түгээж чаддагийг харуулж байна.

боловсруулах компаниа үүсгэн байгуулсан. Улмаар хөрөнгө оруулагчдаа олоод өнөөдөр ингээд нээлтээ хийж байна” гэж Б.Чимэдцэрэн захирал ярьж байсан. Ийм том үйлдвэрийг тийм богино хугацаанд ашиглалтад оруулсан түүх Монголд эднийхээс өөр байхгүй биз ээ. Чин сэтгэл, чиглэсэн зорилго ийм л ялалт амжилтыг авчирдаг ажээ. Орон нутагт тулгаа тулсан хувийн хөрөнгө оруулалттай цогц үйлдвэрийн анхных бас л эднийх болов уу.

АЖИЛ НЬ УРАГШТАЙ, ӨӨДТЭЙ, САЙН САЙХАН ЯВДГИЙН НЭГ НУУЦ НЬ ЭДНИЙ УДИРДЛАГА ХҮНДЭЭ ОНЦГОЙ АНХААРАЛ ТАВЬДАГТАЙ НЬ ХОЛБООТОЙ Ч БАЙЖ МЭДНЭ.

Хүнийхээ сэтгэл санаа, цалин хөлс, нийгмийн асуудал, амьдрал ахуйд нь чин сэтгэлээсээ ханддаг болохоор эдний үйлс цаанаасаа бүтээд явдаг шиг санагдлаа.

Тус компанийн зөвлөх Даваадоржийн Рэгзэнтэй уулзахад: Би төрд 36 жил ажилласан, үүнээс Усны газар найман жил ажилласан юм. Онги Таацын сав газрын захиргааны тулгыг тулж, галыг асаалцсан хүн. Хоёр жилийн өмнөөс энд зөвлөхөөр ажиллаж байна. Арьс

ширний үйлдвэр байгуулах нь зөв. Тэгэхдээ цэвэрлэх байгууламжийг ном дүрмийн дагуу барих нь зөв гэдгийг онцлон анхаарцгаасан. Өнөөдөр бид нээлтээ хийлээ. Маш сайхан залуус энд орж ирж байна. Аймаг, орон нутаг ч маш их дэмжиж байна. Манай энэ компанийн



УСНЫ ГАЗРААС 2021 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД

НЭГ.УВС АЙМГИЙН ХЯРГАС СУМЫН НУТАГТ БИЛҮҮГИЙН ГОЛД ХӨВ, ЦӨӨРӨМ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ХҮЛЭЭЖ АВАВ



Билүүгийн голд хаврын шар ус, зуны хур борооны үерийн усыг боомт (далан) барьж, хуримтлуулах замаар сум орон нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, бэлчээр усжуулалтыг сайжруулах зорилготой. 1.82 сая.м³-ийн эзэлхүүнтэй усан сан, Усан толион талбай – 23.52 га, 20 м-ийн өндөртэй, 258.5 м-ийн урттай боомт, Ус авах болон ус гаргах барилга, үерийн ус гаргах байгууламж болон ус татах суваг бүхий томоохон цогцолборыг барьж байгууллаа.


ХОЁР.ОНГИ ГОЛЫН УРСАЦ НЭМЭГДҮҮЛЭХ “ОРХОН–ОНГИ” ЭКО ТӨСЛИЙН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ХҮЛЭЭЖ АВАВ

Орхон голоос Онги голын урсцыг тэтгэж, Улаан нуурын усны түвшинг нэмэгдүүлж, улмаар говийн бүсийн хүн ам, уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг усаар хангах, эрчим хүч үйлдвэрлэх Онги голын урсац нэмэгдүүлэх зорилготой.

Орхон гол дээр урсцын тохируулга хийж жилд 25.0 сая. м³ урсцыг Орхон голын саваас Онги голын савд ус дамжуулах барилга байгууламжаар (шилжүүлэн тэтгэн) Улаан нуурын усны түвшин нэмэгдүүлэх, улмаар говийн бүсийн хүн ам, уул уурхай хөдөө, аж ахуйн үйлдвэрлэлийг усаар хангах, эрчим хүч үйлдвэрлэхэд оновчтой чиглэгдсэн болно.



ГУРАВ.ГОВИЙН БҮСИЙН ҮЙЛДВЭР, УУРХАЙН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ХҮЛЭЭЖ АВАВ.




Говийн бүсийн эрчимтэй өсөн нэмэгдэж буй хүн ам, үйлдвэр, уурхайн усны эрэлтийг хангах зорилготой бөгөөд эхний ээлжинд газрын доорх усны эх үүсвэрээс хангах ба ус хангамжийн шугам хоолой нь ирээдүйд хойд бүсийн голуудын гадаргын усны эх үүсвэртэй хосолсон байдлаар ажиллах боломжтой байхаар төлөвлөлт хийгдсэн. Төсөл хэрэгжсэнээр Өмнөд говийн бүсэд ус дамжуулах 542 км урт шугам хоолой, 1 сая.м³ багтаамжтай ус нөөцлөх усан сан бүхий ус хангамжийн нэгдсэн дэд бүтэц бий болно.



УСНЫ ГАЗРААС 2021 ОНД ХИЙСЭН ОНЦЛОХ АЖИЛ

ДӨРӨВ. УС АШИГЛАЛТЫН ТАЙЛАНГ УЛСЫН ХЭМЖЭЭНД НЭГТГЭН ГАРГАСАН.

Монгол улсын хэмжээнд 2020 онд унд ахуйд 83.2 сая.м3/жил, эрчим хүчний үйлдвэрлэлд 40.8 сая.м3/жил, хөдөө аж ахуйд 353 сая.м3/жил, үйлдвэрлэл, ахуй үйлчилгээнд 18.6 сая.м3/жил, уул уурхайд 95.4 сая.м3/жил, нийтдээ 591 сая.м3/жил хэмжээтэй усыг ашигласан байна.



ТАВ. УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖИЛ

Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу 2021 онд Усны газарт хаягдал усны дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 96 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хуулийн хугацаанд нь чанартай гүйцэтгэж шийдвэрлэсэн. Жилийн эцсийн байдлаар 12'753'980'533 төгрөгийн төлбөр, нөхөн төлбөрийг ногдуулж, улсын төсөвт 374'352'395.0 төгрөгийг төвлөрүүлээд байна.




УТ төвлөрүүлсэн төлбөр




Сав газрын захиргаадаас хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус зайлуулдаг 4261 аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал усны төлбөрийг ногдуулж, хаягдал усны дүгнэлтээр 180'629'473.3 төгрөгийн ус бохирдуулсны төлбөр ногдуулсан. Байгальд

хаягдал усаа нийлүүлсэн 952 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хаягдал усны дүгнэлтийг гаргаж 65'508'334.89 төгрөгийн ус бохирдуулсны төлбөрийг ногдуулсан байна.

СГЗ-аас гаргасан хаягдал усны дүгнэлтийн тоо




СГЗ-аас хаягдал усанд ногдуулсан төлбөрийн хэмжээ, төг





Канад Улсын "МЕРИТ" төслийн хүрээнд Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг сурталчилан таниулах зорилгын хүрээнд төслийн санхүүжилтээр 2 видео контентийг бэлтгэж олон нийтийн хүртээл болгосон.

Усны газраас “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”-ийг сурталчилан таниулах зорилгоор нийт 18 удаагийн сургалтыг зохион байгуулж, 623 хүнийг хамруулсан.



ЗУРГАА 2021 ОНД ГАЗРЫН ДООРХ УСНЫ ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ АЖЛААР БАТЛАГДСАН НӨӨЦИЙГ 302.0Л/С-ЭЭР НЭМЭГДҮҮЛЖ, НӨӨЦ БАТЛАГДСАН НИЙТ ОРДЫН ТООГ 406-Д ХҮРГЭСЭН.



“Майдар хот”-ын унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн эрэл-хайгуулын ажил, Салхитын мөнгөний ордын баяжуулах үйлдвэрийн технологийн усан хангамжийн эх үүсвэрийн хайгуулын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр хүн амын ус хангамжийн зориулалтаар нээсэн ордууд:

Нийслэлийн Багануур дүүргийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн орд, батлагдсан нөөц 110л/с;

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн

орд, батлагдсан нөөц 4.8л/с усны нөөцийг тус тус батлуулсан.

Рашааны нөөцийн судалгааны ажлын хүрээнд Хульжийн рашааны нөөцийг 4.6 л/с-ээр батлуулсан.

Хувийн хөрөнгө оруулалтын зардлаар: Нийт 8 аж ахуй нэгжийн усны нөөцийг 182.6л/с-ээр батлуулсан

2021 онд нийт газрын доорх усны ордын батлагдсан нөөцийг 302.0л/с-ээр нэмэгдүүлсэн. Нөөц батлагдсан нийт ордын тоог 11-ээр нэмэгдүүлж, нийт 406 орд болсон.

ДОЛОО. ГАЗРЫН ДООРХ УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СҮЛЖЭЭГ ДӨРВӨН ЦЭГЭЭР НЭМЭГДҮҮЛЖ, НИЙТ ГАЗРЫН ДООРХ УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД 309 ЦЭГИЙГ ХАМРУУЛСАН.



Улсын төсвөөр нийт 4 цэг шинээр байгуулсан.

Монгол орны 21 аймгийн 80 сум, Улаанбаатар хотын 8 дүүргийг хамарсан байна.

Дэлхийн банкны дэрэгдэх УНБ 2030 төсөлтэй хамтран хэтийн төлвийг тооцох загварчлалыг хиймэл оюун ухааны дэд салбар болох Машин сургалтын Machine Learning арга хэрэгслийг ашиглан хөгжүүлсэн.

буюу байгалийн горимд 3 мониторингийн цооног шинээр гүйцэтгэж, хагас автомат багаж суурилуулан нэгдсэн сүлжээнд холбосон. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн БХГ-г XIX, XXI талбайд газрын доорх усны хяналт шинжилгээний 23 цэгийг (17 цэг бүрэн автомат, 6 цэгт хагас автомат багаж суурилуулсан) газрын доорх усны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээнд холбосон.

2021 онд: Багануур дүүргийн усан хангамжийн эх үүсвэрийн мониторингийн цооногт 1 бүрэн автомат багаж суурилуулж, говийн бүсийн цэнгэг усны ордод

НАЙМ. САВ ГАЗРЫН ЗАХИРГААДЫН УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛСЭН.



2030 Усны нөөцийн бүлгийн дэмжлэгтэйгээр улсын УННМТ-г шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

2021 онд 9 сав газрын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг сав газрын захиргаад дотоодын болон олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэж байна.

Улсын УННМТ хэрэгжилтийн байдалд өгсөн үнэлгээ:

Д.д	Стратеги зорилт	Хэрэгжилтийн үнэлгээ, %	Үнэлгээ
1	Хүн амын баталгаат, эрүүл аюулгүй усаар хангах	68	Үр дүн, ач холбогдол “сайн”
2	Хөдөө аж ахуйн салбарыг хэрэгцээт усаар хангах	62	Үр дүн, ач холбогдол “сайн”
3	Үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний салбарыг хэрэгцээт усаар хангах	47	Үр дүн, ач холбогдол “дунд зэрэг”
4	Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах	65	Үр дүн, ач холбогдол “сайн”
5	Усны оновчтой менежментийг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах	64	Үр дүн, ач холбогдол “сайн”
Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		61% хэрэгжилттэй	

ХӨВСГӨЛ НУУРТ ЖИВСЭН ОНГОЦЫГ 36 ЖИЛИЙН ДАРАА ТАТАН ГАРГАЛАА



Монгол орны цэнхэр сувд болсон Хөвсгөл нуурт 36 жилийн өмнө живсэн “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг саяхан амжилттай зохион байгууллаа. Манай орны гадаргын усны 70 шахам хувийг дангаараа эзэлдэг энэ нуурыг цэвэр ариун байлгах нь хүн төрөлхтний өмнө хүлээсэн бидний үүрэг билээ. Хөвсгөл нуурт 1985 онд живсэн уг онгоц нь 43,3 метр урттай, 309 тн жинтэй байсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилга, Засгийн газрын шийдвэрийн дагуу хийгдсэн энэ ажил нь 9 сарын 27-оос 11 сарын 05 хүртэл үргэлжилсэн билээ. Хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаа нь Монгол Улсад усны гүнд зохион байгуулагдсан анхны бөгөөд түүхэн арга хэмжээ болсон юм. Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хүрээнд хийгдсэнээрээ бас онцлог билээ. Энэ ажлын тухай Усны газрын дарга Ш.Мягмараас тодруулхад: “Хөвсгөл нуур бол бидэнд заяагдсан үнэлж баршгүй

эрдэнэ юм. Цэвэр усны нөөц багасах хандлага илт ажиглагдаж байгаа энэ үед энэ ажлыг амжилттай зохион байгууллаа. Өвлийн цагт энэ нуурын мөсөн дээгүүр бензин, бордоо ачсан машин тэрэг олноор явдаг юм байна. Одоо нуурын гүнд 30 гаруй машин бий гэсэн тооцоо бий. Эдгээрийг үе шаттай гаргана. Саяхан “Сүхбаатар” онгоцыг татан гаргах ажиллагаанд БХЯ, БОАЖЯ, ЗХЖШ, ОБЕГ зэрэг олон байгууллага, аж ахуйн нэгжийн 120 гаруй хүн 50 гаруй техник хэрэгсэлтэйгээ оролцлоо. Мөн Онцгой байдлын байгууллагын 20 гаруй усчин аврагчид 16 метр усны гүнд хөлөг онгоцыг холбох, хөшүүрэг хийх, гүн хэмжих, битүүмжлэх даалгаврыг 33 хоногт 100 удаагийн шумбалтаар ажилтга хийж гүйцэтгэсэн байна. Энэхүү үйл ажиллагаа нь Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах онцгой ач холбогдолтой ажил боллоо” гэж ярилаа.




ОНОН-УЛЗ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

Онон болон Улз голын сав газар нь Монгол орны зүүн хойд хязгаарт нийт 66018.3 км.кв оршдог. Номхон далайн ай савд багтах бөгөөд Онон голын сав газар нь 3 аймгийн 11 сумын нутаг дэвсгэрийг хамран 28715.7 км.кв, Улз голын сав газар нь 2 аймгийн 11 сумын нутаг дэвсгэрийг хамран 37302.6 км.кв тус тус хамран оршдог. Онон голын сав газар: Номхон далайн ай савд

хамаарах хамгийн том усан судал болох Амар мөрний эх нь Монгол орны байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутгуудын нэг Хан Хэнтийн уулсаас эх авсан Онон гол бөгөөд энэ нь Амар мөрний нийт ус хурах талбайн 9 хувийг эзэлдгийн дээр бусад цутгал голуудаас хамгийн цэвэр, тунгалаг устай нь юм. Онон гол Хан Хэнтийн салбар уулсын үзэсгэлэнт сайхан хангай уулс

хоорондын хөндийнүүдээр урсаж буй голууд, үржил шимт хөрс шороо, ой мод, өвс ургамал, төрөл бүрийн жимс жимсгэнэ ургах амьдралын таатай нөхцөлийг бүрдүүлэн Хан Хэнтийн дархан цаазат газар, Онон-Балжийн байгалийн цогцолбор, Гутайн даваа Хөмүүл голын байгалийн цогцолбарт газруудад хамаарч байдгаараа онцлог юм.



САВ ГАЗРЫН ЗАХИРГАА НЬ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Сав газрын захиргааны талаар авах арга хэмжээний тухай” 254 дүгээр тогтоолоор байгуулагдаж Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 08 дугаар сарын 15-ны А-231 тушаалаар Онон голын сав газрын захиргаа, 2013 оны 07 дугаар сарын 30-ны А-219 тушаалаар Улз голын сав газрын захиргаа тус тус байгуулагдан бүтэц, орон тоо дүрмээ батлуулан ажиллаж байгаад Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн “Сав газрын зарим захиргааны татан буулгаж, нэгтгэн зохион байгуулах байршлыг тогтоох, бүтэц, орон тоо, дүрмийг батлах тухай” А/83 тушаалаар Онон-Улз голын сав газрын захиргаа байгуулагдсан.



ЗАХИРГААНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Захиргааны дарга **Б.Баяртогтох**

Газрын доорх усны нөөц хяналт, шинжилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн **И.Алтмаа**
Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн **Б.Баатарсүрэн**
Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, олон нийт сургалт хариуцсан мэргэжилтэн
Газарзүйн мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн **Т.Бямбажаргал**
Нуурын экосистемийн үнэлгээ, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн **Б.Ууганбаяр**
Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн **Б.Баяржаргал**

Усны чанар, экологи, төлбөрийн асуудал

хариуцсан мэргэжилтэн **Б.Уранбилэг**
Усны барилга байгууламж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн **А.Сугарцэрэн**
Жолооч **Б.Идэрбат**
Нягтлан бодогч (гэрээт) **Б.Цэндмаа**
Архив, бичиг хэргийн ажилтан/Нярав (гэрээт) **Д.Болормаа**
Үйлчлэгч(гэрээт) **Р.Балжмаа**
Харуул хамгаалалтын ажилтан (гэрээт) **Б.Цэрэнжав**,
Б.Батдорж, **Д.Энхбаяр**, **Ч.Намуун** нарын 17 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг.

2021 ОНД ХИЙЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД, ҮР ДҮН:

Улз голын эхийг бүрэлдүүлж буй Эхэн бүрдийн Их ба Бага бүрдийг хашиж, хамгаалах ажлыг зохион байгуулсан:


Их бүрд: Дэлхийн Байгаль Хамгаалах сангийн Монгол дахь

хөтөлбөрийн газар болон Дэлхийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын хамтран хэрэгжүүлж байгаа “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал”

төслийн санхүүжилтээр Улз голын эх Их бүрдийн 3 булгийг хашаалж, хамгаалах ажлыг нутгийн иргэдийн /Онон, Ангирт багийн 50 иргэн/ оролцоотой зохион байгуулсан.





Бага бүрд: ОУГСГЗ-ны дотоод нөөц бололцоог ашиглан Норовлин сумын нутаг Улз голын эх Бага бүрдийн хашаа хамгаалалтыг сэргээн засварлах ажлыг албан зохион байгуулсан



Онон голын сав газрын УННМТ-ний хэлэлцүүлэг: ДБХС-ийн санхүүжилтээр Онон голын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, шинээр боловсруулах төлөвлөгөөнд санал авах хэлэлцүүлгийг “Ус судлал хөгжлийн хүрээлэн”-тэй хамтран Онон голын сав газарт хамаарах сумдад зохион байгуулсан.

Мөн ОУГСГЗ-ны ажлын хэсэг Хэнтий аймгийн 6 сум, Дорнод аймгийн 1 суманд ажиллан холбогдох төрийн албан хаагчдад “Усны бланс тооцох аргачлал” сургалт зохион байгуулж, сумын Засаг даргаар хамтарсан ажлын хэсэг томилуулан мэдээллийг нэгтгэн гарган авч, ус ашиглалтын балансын хэмжээг тооцоолж, сав газрын УННМТ-ний хэлэлцүүлгүүдэд танилцуулах ажлыг зохион байгуулсан.



2022 ОНД ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖЛУУД:

- Онон, Улз голын сав газрын суурь судалгаанд нэмэлт тодотгол хийх судалгааны ажил зохион байгуулах
- УННМТ төлөвлөгөөг шат шатны оролцогч талуудыг хамруулсан явцын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж саналыг тусган, шинэчлэн боловсруулах, батлуулах
- Томоохон ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудын ойролцоо газрын доорх усны автомат хэмжилтийн багажтай цооног байгуулах

ГОЛ УСНЫ САН, СУДРУУД

Бидний өвөг дээдэс байгалиа хайрлаж хамгаалж ирсэн нандин сайхан уламжлалтай. Тэдгээрийн нэг нь уул овоогоо тайж тахих явдал. Зөвхөн уул овоог бус гол мөрөн, рашаан усаа хамгаалж ирсэн нандин уламжлалтай байжээ. Буддын соёлын “Махгала” нийгэмлэг соён гэгээрүүлэх, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тэд олон жилийн туршид сурвалжлан цуглуулж, монголчуудын байгаль

хамгаалах уламжлал, томоохон өв болох уул хайрханы сан тахилгын 400 орчим судар номын сан хэмрөгтэй болоод байгаа гэнэ. Тэдгээрийн дотор нуур далай, гол мөрөн, ус булгийн тахилгын олон судар байдаг ажээ. Тус нийгэмлэг нь “Монголчуудын гол ус ба хамгаалах ёс заншил, өв уламжлал” номыг бүтээхээр төлөвлөсөн байна. Эднийд дараах гол мөрөн, ус булгийн сан судар байна.

- Идэр, Тэрхийн голын сан
- Мухар хужиртын рашааны сан
- Мухар хужиртын сан хэмээх өөр нэгэн судар
- Мухар хужиртын сан тахилга
- Цагаан нуур, Хоргын сан
- Тэрийн цагаан нууын сан
- Ёл өргөөдийн сан
- Сангийн далайн сан
- Туул голд урсах лус савдгийн сан
- Шаргалжуутын рашааны сан
- Онгийн голын сан
- Орхон голын ёс
- Хэрлэний ёс тахилга
- Дэлгэрмөрний ёс тахилга
- Голын ёс
- Ариг усны ариусгал тахилга
- Хөвсгөл далайн эзэнд алтан ундаа өргөх ёс
- Харзгайн халуун рашааны сан тахилга
- Сэлэнгэ мөрний сан
- Төхөмийн сан
- Ононгийн халуун рашааны сан тахилга
- Увс нуурын сан гэхчилэн олон олон рашаан усны сан судар байдаг ажээ.

